



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 331

Улаанбаатар хот

“Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох,  
актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт,  
шалгалт хийх, тайлан гаргах журам”-ыг  
шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.9 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 212, 2008 оны 41, 2011 оны 335 дугаар тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай

3. Хавсралтаар шинэчлэн батлагдсан “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах журам”-ыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хянан шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000936